



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2024 оны 01 сарын 20 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Үнэн ба зөв нам (ҮБЗН)-ын дүрмийн өөрчлөлт
болон намын даргыг улсын бүртгэлд
бүртгэхээс татгалзах тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, танхимын тэргүүн Г.Алтанчимэг, Ч.Хосбаяр, шүүгч Б.Амарбаясгалан, Д.Батбаатар, Б.Батцэрэн, Г.Банзрагч, Х.Батсүрэн, М.Батсуурь, Н.Баярмаа, Н.Батзориг, Н.Батчимэг, С.Батдэлгэр, П.Золзаяа, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Б.Цогт, Ц.Цогт, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

Үнэн ба зөв нам (ҮБЗН)-ын дүрмийн өөрчлөлт болон намын даргыг улсын бүртгэлд бүртгүүлэх тухай өргөдлийг шүүгч Б.Батцэрэнгийн илтгэснээр хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Үнэн ба зөв нам (ҮБЗН)-ыг төлөөлж А.Отгонбаатараас 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Улсын дээд шүүхэд гаргасан өргөдөлдөө "... Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 17 дугаар зүйлийн 17.4, намын дүрмийн 5.8.1-д заасны дагуу 2024 оны 12 дугаар сарын 07-ны өдөр намын төлөөллийн төв байгууллага болох Төв хорооны хурлаа хийж, намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулсан болно. Үнэн ба зөв намын даргаар 2017 оноос хойш өнөөдрийг хүртэл А.Отгонбаатар миний бие ажиллаж байна. 2024 оны 11 дүгээр сарын 06-нд намын Байнгын хороо хуралдаж, 10 дугаар тогтоолоор намын даргад дахин А.Отгонбаатарыг сонгох тухай шийдвэр гаргасан. Мөн 2024 оны 12 дугаар сарын 07-ны өдөр намын Төв хороо хуралдаж намын даргаар дахин намайг сонгосон болно. Иймд А.Отгонбаатар намайг Үнэн ба зөв намын даргаар шинэчлэн бүртгэж, намын даргын бүртгэлийг намын гэрчилгээнд тэмдэглүүлэх хүсэлт гаргаж байна" гэжээ.

ҮНДЭСЛЭХ нь:

Үнэн ба зөв нам (ҮБЗН)-ын дүрмийг шинэчлэн, Улсын дээд шүүхэд бүртгүүлэхээр ирүүлсэн өргөдөл, түүнд хавсарган ирүүлсэн баримтууд болон намын даргыг бүртгүүлэх хүсэлтийг Улс төрийн намын тухай хуулийн зохицуулалт, уг хуулиар шаардсан улс төрийн намын бүрдэл хэсэг, агуулгад нийцүүлэн нийт шүүгчийн хуралдаанаас хянаад дараах үндэслэлээр бүртгэхээс татгалзаж шийдвэрлэлээ.

Нэг.Намын дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах болон даргыг сонгосон ажиллагааны талаар:

Үнэн ба зөв нам (ҮБЗН)-ын дүрмийн (2017 оны) 5.7-д “Төв хорооны нийт төлөөлөгчдийн олонх нь оролцсоноор хуралдааныг хүчинтэйд тооцно.”, 5.8-д “Намын Төв хороо нь дараах бүрэн эрхтэй.”, 5.8.1-д “Намын Их хурлаар баталсан намын дүрэм, мөрийн хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулах, сонгогдсон бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах асуудлыг шийдвэрлэх;”, 5.8.3-т “Намын дарга, ... сонгох; гэж зааснаар намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, намын даргыг сонгох эрх нь тус намын төлөөллийн төв байгууллага болох Төв хорооны бүрэн эрхэд хамаарч байна.

2024 оны 12 дугаар сарын 07-ны өдөр хуралдсан намын Төв хорооны хурлыг дараах журмаар зарлан хуралдуулж, холбогдох шийдвэрийг гаргажээ.

1.Намын дүрмийн 5.5-д “Намын Төв хорооны хуралдааныг намын гүйцэтгэх төв байгууллагаас жилд нэгээс доошгүй удаа зарлан хуралдуулна.”, 7.1-д “Намын өдөр тутмын ажлыг эрхлэх чиг үүрэг бүхий намын гүйцэтгэх төв байгууллага нь Байнгын хороо байна.”, 7.2-т “Байнгын хороо нь Ерөнхий нарийн бичгийн даргыг оролцуулан 9 хүний бүрэлдэхүүнтэй байна. Байнгын хорооны бүрэлдэхүүнийг намын Төв хорооноос томилно.” гэж тусгаснаар намын Төв хорооны хурлыг товлон зарлах, хуралдуулах эрх Байнгын хорооны гишүүдэд олгогдсон байна.

Гэтэл өргөдөлд хавсарган ирүүлсэн баримтаас үзвэл, Үнэн ба зөв намын дарга А.Отгонбаатарын 2024 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн намын “Төв хороог хуралдуулах тухай” 01/771 дүгээр албан бичгээр 2024 оны 12 дугаар сарын 07-ны өдөр намын Төв хорооны хурлыг товлон хуралдуулжээ, үүнийг намын дүрмийн дээрх заалтуудад нийцсэн гэж үзэхгүй.

Өөрөөр хэлбэл, намын дүрмээр Төв хорооны хуралдааныг зарлан хуралдуулах эрхийг намын даргад олгоогүйгээс гадна намын дүрмийн 5.5-д заасан гүйцэтгэх төв байгууллага буюу Байнгын хорооноос Төв хорооны хуралдааныг зарлан хуралдуулах шийдвэр гаргасан эсэх нь өргөдөлд хавсаргасан баримтуудаар тогтоогдохгүй байна.

2.Мөн намын дүрмийн 5.1-д “Намын Төв хороо нь намын төлөөллийн төв байгууллага мөн. Намын төв хорооны төлөөлөгчид нь албан тушаалын болон сонгуулийн зарчмаар сонгогдоно.”, 5.2-т “Төв хорооны бүрэлдэхүүнд албан тушаалын зарчмаар дараах намын гишүүд орно.” Намын дарга, дэд дарга, Удирдах зөвлөлийн гишүүн, Нийслэлийн намын хорооны дарга, дэд дарга, Аймаг дүүргийн намын хорооны дарга, Бодлого судалгааны хүрээлэнгийн удирдах зөвлөлийн дарга, Монгол Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Намаас төрийн улс төрийн албан тушаалд сонгогдсон болон томилогдсон гишүүн; Аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хуралд төлөөлөгчөөр сонгогдсон гишүүн.”, 5.3-т “Сонгуулийн зарчмаар сонгогдох байнгын хорооны төлөөлөгчдийг аймаг, нийслэл, дүүргийн намын хороод болон намын гүйцэтгэх төв байгууллага сонгоно. ...” гэж тус тус заасан.

Төв хорооны 2024 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээс үзвэл “... Хуралд оролцох Төв хорооны нийт 54 хүнээс 12 нь ирээгүй дийлэнх олонх нь ирсэн ...” гэх боловч тус хорооны хуралд оролцсон төлөөлөгчдийг хэрхэн сонгосон, хурлын товыг төлөөлөгчид мэдэгдсэн баримт, дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг баталсан санал хураалтын талаар баримт ирүүлээгүй бөгөөд уг хурал нь дүрэмд заасны дагуу хуралдсан эсэх нь эргэлзээтэй байна.

Иймд 2024 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн Үнэн ба зөв намын Төв хорооны хурлыг хүчинтэйд тооцох үндэслэлгүй.

Хоёр. Намын дүрмийн өөрчлөлтийн талаар:

1. Улс төрийн намын тухай хууль (2023 оны шинэчилсэн найруулга)-ийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т ““намын гишүүнээс түдгэлзэх” гэж намын гишүүний эрхгүй, намын гишүүний, эсхүл намын дэмжигчийн хувиар намын үйл ажиллагаанд оролцохгүй байхыг;”, 15 дугаар зүйлийн 15.2.3-т “намын гишүүнээр элсэх, намын гишүүнээс түдгэлзэх, намын гишүүний эрх, үүрэг, намын гишүүнээс хасах болон бусад сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл”-ийг намын дүрэмд тусгахаар заасан. Гэтэл тус намын дүрэмд “намын гишүүнээс түдгэлзэх” үндэслэлийг тодорхой зааж тусгаагүй нь хуулийн дээрх шаардлагыг хангахгүй байна.

Тус намын дүрмийн 2.10.7-д “Намын гишүүнээс түдгэлзэх, гарах”, 2.13-т “Намын гишүүнчлэлээс түдгэлзэх, гарах, хасах” гэж намын гишүүний өөрийн хүсэлтээр намаас “гарах” талаар тусгасан боловч ямар тохиолдолд намын гишүүнээс түдгэлзэх, хасах, сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл, үр дагавар үүсэх талаар тодорхой тусгах шаардлагатай.

2. Улс төрийн намын тухай хуулийн (цаашид Хуулийн гэх) 15 дугаар зүйлийн 15.2.4-т “намын удирдах дээд байгууллага, төлөөллийн төв байгууллага, гүйцэтгэх төв байгууллага, хяналтын байгууллага болон бусад байгууллага, тэдгээрийн бүрэлдэхүүн, бүрэн эрхийн хугацаа, эрх хэмжээ, хуралдуулах, шийдвэр гаргах журам”-ыг намын дүрмээр зохицуулахаар заасан. Үнэн ба зөв намын удирдах дээд байгууллага нь Их хурал, төлөөллийн төв байгууллага нь Төв хороо, гүйцэтгэх төв байгууллага нь Байнгын хороо, хяналтын байгууллага нь Хариуцлагын хороо байхаар заасан, мөн тэдгээрийн бүрэлдэхүүн, бүрэн эрхийн хугацаа, хуралдуулах, шийдвэр гаргах талаарх зохицуулалт байгаа боловч намын Хариуцлагын хорооны эрх хэмжээг тодорхой тусгаагүй дараах зөрчлүүд тогтоогдож байна.

Хуулийн 18 дугаар зүйлийн 18.4-т “Намын хяналтын байгууллага дараах маргааныг хянан шийдвэрлэж, шийдвэртээ үндэслэлээ тодорхой бичнэ.”, 18.4.1-д “намын дүрэм зөрчсөн эсэх;”, 18.4.2-т “нам болон түүний гишүүн хооронд үүссэн;”, 18.4.3-т “намын дотоод сонгуультай холбогдон үүссэн;”, 18.4.4-т “намын санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой.” гэж заасан, намын дүрэмд хариуцлагын хорооны эрхийг бүрэн тусгаагүй, мөн Хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журам, тухайлбал, хурлын дараалал, хэн хэрхэн яаж оролцох, нотлох баримт гаргах эрхийг хангах, хуралдаан хаалттай, нээлттэй явагдах нөхцөл зэргийг тусгаагүй.

Түүнчлэн намын дүрмийн 12.1-д “Намын Хариуцлагын хорооны хүсэлтээр, намын дүрмийг тайлбарлах, дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих, хэрэглэхтэй холбогдон үүссэн эсвэл намын дотоод маргаан, сонгуультай холбогдон үүссэн маргааныг хянан хэлэлцэж, мэргэжлийн дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий маргаан хянан шийдвэрлэх зөвлөлийн гишүүдийг намын Их хурлаас 4 жилийн хугацаагаар сонгоно. 40-өөс доошгүй хувь нь аль нэг хүйсийн төлөөлөл байна. гэж тусгасан нь намын хяналтын байгууллага буюу Хариуцлагын хороо хараат бусаар ажиллаж дотоод маргааныг шийдвэрлэхэд сөргөөр нөлөөлөх үр дагавартай. Энэ нь хуулийн 18 дугаар зүйлийн 18.3-т “Намын хяналтын байгууллага хараат бусаар ажиллах бөгөөд түүний үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно” гэж заасанд нийцэхгүй.

3. Хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т “Энэ хуулийн 16.1-д заасан байгууллагыг бүрдүүлэхдээ дараах шаардлагыг хангана.”, 8.2.1-д “нууц санал хураалт явуулах;”, 8.2.2-т “гишүүдийн оролцоо, ил тод байдлыг хангах;”, 8.2.3-т “нэр дэвшүүлэхдээ аль нэг хүйсийн төлөөлөл 30 хувиас доошгүй байх.”, 8 дугаар зүйлийн 8.3-т “Энэ

хуулийн 16.1-д заасан байгууллагын болон намын бусад хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар асуудлыг шийдвэрлэх, цөөнхийн саналыг хэлэлцэх боломж олгож хүндэтгэн үзэх бөгөөд тодорхой асуудлыг дийлэнх олонхын саналаар шийдвэрлэхээр намын дүрэмд зааж болно.” гэснийг намын дүрэмд тусгаагүй орхигдуулснаас гадна, намын дүрмийн 4.2-т “Дараах сонгуульт албан тушаалтнууд нь намын их хурлын төлөөлөгчид байна.”, 4.3-т “Намын анхан болон дунд шатны нэгж, намын дэргэдэх бодлого судалгааны хүрээлэнгээс дараах тооны гишүүдийг их хурлын төлөөлөгчөөр сонгоно.” гэсэн нь Их хурлын бүрэлдэхүүнийг хэрхэн яаж сонгох, хэдэн гишүүнтэй байх талаар тодорхой заагаагүй.

4.Хуулийн 20 дугаар зүйлийн 20.4-т “намын дүрмийг санаатай зөрчсөн, эсхүл намын үнэт зүйл, зарчмыг ноцтой зөрчсөнөөс бусад тохиолдолд намын гишүүнээс хасахыг хориглоно.” гэж заасан, Үнэн ба зөв намын дүрэмд “санаатай зөрчил”, “ноцтой зөрчил”-ийг тодорхойлоогүй, ямар үйлдэл гаргасан тохиолдолд намын гишүүнийг ноцтой зөрчил гаргасан, санаатай зөрчил гэж үзэж, намын гишүүнээс хасах үр дагавар үүсэх талаар намын гишүүдээрээ хэлэлцэж дүрэмдээ тусгаж, гишүүдэд ойлгомжтой байдлаар нэрлэн заах нь ач холбогдолтой юм.

5.Тус намын дүрэмд намын даргад хэрхэн яаж нэр дэвших журам тодорхойгүй, түүнчлэн намын даргыг чөлөөлөх, огцруулах үндэслэлийг тодорхой нэрлэн заагаагүй нь хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-д зааснаар намын дүрэмд намын даргыг сонгох, чөлөөлөх, огцруулах үндэслэлийг тодорхой заах шаардлагыг хангахгүй байна.

6.Хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6-д “намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах журам”-ыг заахаар, мөн хуулийн 17 дугаар зүйлийн 17.4-т “Намын төлөөллийн төв байгууллагын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь санал гаргавал намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж болно. Энэ нэмэлт, өөрчлөлт нь намын дүрмийн гуравны нэгээс хэтрэхгүй байна” гэж тус тус заасан. Гэтэл намын дүрмийн 5.8-д “Намын Төв хороо нь дараах бүрэн эрхтэй:”, 5.8.1-д “Намын Их хурлаар баталсан намын дүрэм, мөрийн хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулах, сонгогдсон бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах асуудлыг шийдвэрлэх;” гэсэн нь хуулийн 17 дугаар зүйлийн 17.4-т заасантай нийцэхгүй.

7.Намын дүрмийн 2.8-д “Намын гишүүнийг намын дотоод сонгуульт ажил, төрийн болон улс төрийн удирдах албан тушаалд нэр дэвшүүлэх, сонгуулийн хорооны гишүүнийг, сонгох, томилох асуудлыг намын төв хорооны журмаар зохицуулна.” гэсэн боловч Төрийн улс төрийн албан тушаалд болон намын удирдах албан тушаалд нэр дэвшигчийг чөлөөлөх, тэдгээрт жендэрийн тэгш байдлыг хангах талаар намын дүрэмд тусгаагүй байна.

8.Хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.9-д “Намын хөрөнгө, орлогыг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам;” 32 дугаар зүйлийн 32.1-д “Гишүүний татварын хэмжээ, бүрдүүлэлтийг тухайн намын дүрмээр тогтооно”, 27 дугаар зүйлийн 27.13-т “Төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг сонгуулийн төв байгууллагын шийдвэрийн дагуу намын төв байгууллагад олгох бөгөөд салбар болон бүтцийн нэгжид хуваарилах асуудлыг намын дүрмээр зохицуулна”, 41 дүгээр зүйлийн 41.3-т “Энэ хуулийн 41.1-д заасан арга хэмжээг авахад хүргэсэн алдаа, зөрчлийг намын орон нутгийн нэгж гаргасан тохиолдолд тухайн асуудлыг нам дүрмээр зохицуулна. гэсэн намын дүрмээр зайлшгүй зохицуулах асуудлыг орхигдуулсан.

9.Хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.10-т “Намын салбар болон бүтцийн нэгжийг байгуулах, татан буулгах үндэслэл, журам”-ыг намын дүрэмд тодорхой тусгах шаардлагатай.

10.2023 оны Улс төрийн намын тухай хуулийн үзэл баримтлал, танилцуулга, 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Улсын Их Хурлын Байнгын хорооны болон Нэгдсэн хуралдааны тэмдэглэлээс үзэхэд, Улс төрийн намын тухай хуулийг шинэчлэн батлахдаа намын гишүүд намын дарга эсхүл үүсгэн байгуулагчаас шууд хараат байгаа байдал, нэг хүн тойрсон бүлэглэл маягийн хэлбэртэй, нэг гэр бүлийн, нэг аж ахуй нэгжийн нам болсныг өөрчлөх, намын гишүүд нь эзэн байх, намын шийдвэр гаргах үйл ажиллагааг намын гишүүдийн хяналтад байлгах, намын гишүүдийг шийдвэрт оролцуулдаг, хяналт тавьдаг, хариуцлага тооцдог эрх зүйн орчинг бүрдүүлэх зорилгоор баталжээ.

Намын дүрмийн 5.5-д “Намын Төв хорооны хуралдааныг намын дарга жилд нэгээс доошгүй удаа зарлан хуралдуулна.”, 7.5-д “Намын Байнгын хорооны хуралдааныг намын дарга зарлан хуралдуулах ба хуралдааныг даргална. Түүнийг эзгүйд Ерөнхий нарийн бичгийн дарга хуралдааныг удирдана.” гэж Төв хороо, Байнгын хорооны хуралдааныг “намын даргын санал болгосноор хуралдуулах”-аар дүрэмд тусгасан нь хуулийн үзэл баримтлалд нийцэхгүй байна.

Гурав.Намын даргыг бүртгүүлэх талаар:

Үнэн ба зөв намын дүрэм (2017 оны)-ийн 5.8-д “Төв хороо нь дараах бүрэн эрхтэй”, 5.8.3-т “Намын дарга, ... сонгох”, 6.2-т “Үнэн ба зөв” намын дарга, дэд даргыг намын байнгын хорооноос 6 жилийн хугацаагаар сонгох бөгөөд намын дарга дараах бүрэн эрхтэй байна.” гэж тус тус заасан.

Тус нам нь анх 2017 оны 03 дугаар сарын 10-ны өдөр нам үүсгэн байгуулах хурлаа хийж, 06 дугаар тогтоолоор тус намын даргаар А.Отгонбаатарыг дэмжсэн, улмаар нам үүсгэн байгуулсныг улсын бүртгэлд бүртгүүлэхээр хүсэлт гаргасныг Монгол Улсын дээд шүүхийн 2017 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 08 дугаар тогтоолоор Үнэн ба зөв намыг улсын бүртгэлд бүртгэж, улсын бүртгэлийн гэрчилгээ олгохоор шийдвэрлэсэн боловч намын даргыг улсын бүртгэлд бүртгээгүй байна.

Үүнээс хойш Үнэн ба зөв намын Байнгын хорооны 2024 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн “Намын дарга сонгох тухай” 10 дугаар тогтоолоор хуралд оролцсон төлөөлөгчдийн 100 хувийн саналаар (нууц санал хураалт) баталж, мөн Төв хорооны 2024 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн хурлын 04 дүгээр тогтоолоор намын даргаар А.Отгонбаатарыг сонгосон баримт ирүүлжээ.

Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга) 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн бөгөөд уг хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлийг “Нам өөрийн дүрэм, хөтөлбөр, дотоод зохион байгуулалтыг Улс төрийн намын тухай (Шинэчилсэн найруулга)-тай нийцүүлэх арга хэмжээг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор авч хэрэгжүүлэх бөгөөд уг өөрчлөлтийг Улсын дээд шүүхэд 30 хоногийн дотор хүргүүлнэ.” гэж 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан байна.

Хуулийн дээрх зохицуулалтын дагуу Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга) хүчин төгөлдөр болсон өдрөөс өмнө байгуулагдсан намуудын тухайд өөрийн намын дүрмийг шинэ хуулийн агуулгад нийцүүлэн бүртгүүлэх үүрэг үүсэж байгаа тул Улсын дээд шүүх нь улс төрийн намын аливаа бүртгэл хийхдээ шинэ хуулийг хэрэглэх буюу хуульд нийцсэн намын дүрмийн хэрэгжилтийг хянах юм.

Үнэн ба зөв нам дүрмээ Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-д нийцүүлэн баталж, уг дүрмийн дагуу намын даргыг сонгох нь зүйтэй гэж Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас шийдвэрлэв.

Иймд дээрх үндэслэлүүдээр Үнэн ба зөв нам (ҮБЗН)-ын хүсэлтийг хангах үндэслэлгүй, нам өөрийн дүрэмд заасан журмын дагуу дахин хуралдаж, дээрх зөрчлүүдийг арилгасны үндсэн дээр Улс төрийн намын тухай хуульд нийцүүлэн намын дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг шинэчлэн баталж, хуульд заасан хугацаанд Улсын дээд шүүхэд дахин хандах эрхтэй.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1-д заасныг тус тус удирдлага болгон ТОГТООХ нь.

1.Улс төрийн намын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5-д заасныг баримтлан Үнэн ба зөв нам (ҮБЗН)-ын дүрмийн өөрчлөлт болон намын даргыг бүртгэхээс татгалзсугай.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

Б.БАТЦЭРЭН